



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/03

Хэрлэнбаян-Улаан тосгон

**Үндсэн хөрөнгийг акталж данснаас
хасах тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67-р зүйлийн 67,5 дэх заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйл "Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын" тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус тосгоны Эрүүл мэндийн төвийн хэрэгцээ шаардлага хангахгүй болсон олон жил ашиглагдсан хэрэглэхээ больсон болон мараалын элэгдэлд орж хуучирсан 47 нэр төрлийн 57 ширхэг, 14.617.406,70 (Арван дөрвөн сая зургаан зуун арван долоон мянга дөрвөн зуун зургаан төгрөг, далан мөнгө)-ний балансын үнэтэй үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг Хэнтий аймгийн орон нутгийн өмчийн газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 164 тоотыг үндэслэн үндсэн хөрөнгөөс хасаж актлан данснаас хасахыг нягтлан бодогч (Ю.Батбаяр)-т үүрэг болгосугай.

2. Актлагдах эд хөрөнгийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3. Актлагдсан эд хөрөнгийг үндсэн хөрөнгөөс хасаж актлан устгахыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга болон нярав (Ц.Оюун-Эрдэнэ)-д даалгасугай.

ЭРХЛЭГЧ  Н.МӨНХТУЯА

